

“Өсвөр Ye Хүнс” ОНӨААТҮГ-ын захирлын
... оны ... дугаар сарын 05-ны
едрийн A/47 дугаар тушаалын хавсралт

ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БУЦААН
ТАТАН АВАХ, АКТЛАХ, ХАРИЛЦАГЧИДАД БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь хүнсний чанар, эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг цэцэрлэг, сургуулиудаас татан авах, актлах, харилцагчидад буцаан олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, актлах, харилцагчидад буцаан олгоход Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, болон бусад холбогдох стандарт, дүрэм, энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. “Актлах” гэж чанарын үзүүлэлтийн багаж болон мэдрэхүйн үзүүлэтээр хүний амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон эсхүл гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг захирлын тушаалаар няравын тооцоо данснаас хасаж устгахыг хэлнэ.

Гурав. Шаардлага хангагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар мэдээлэх

- 3.1. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлын шаардлага хангагүй талаар дараахь байдлаар мэдээлнэ.
 - 3.1.1. Цэцэрлэг шаардлага хангагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний талаар холбогдох албан тушаалтан болон байгууллагын утсаар, цахим шуудангаар мэдээлнэ;
 - 3.1.2. Холбогдох албан тушаалтан нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нэлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай дээд албан тушаалтандaa мэдэгдэж дараагийн шатны арга хэмжээг авна;
 - 3.1.3. Дээд албан тушаалтны шалгалтын явцад бүтээгдэхүүн эрүүл ахуйн болон аюулгүйн үзүүлэлтийг хангагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг тогтоосон тохиолдолд холбогдох албан тушаалтан харилцагч компаниййн хүнсний мэргэжилтэнтэй холбогдон утсаар болон албан бичгээр тус тус мэдэгдэж буцаах эсвэл актлах арга хэмжээ авна;

Дөрөв. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах

- 4.1. Тухайн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авна.
- 4.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах тохиолдолд хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд. бүтээгдэхүүнээ хүнсний сүлжээнээс татан авна:

 - 4.3 Хоол хүнснээс шалтгаалсан өвчлөл гарсан;
 - 4.4 тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага болон аюулгүйн үзүүлэлтийг хангагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг хяналт шалгалтаар тогтоосон;
 - 4.5 тухайн импортолсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулын талаархи

сэрэмжлүүлэн олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн

4.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан аваадаа дараах үүрэг хүлээнэ:

4.7 Нийт харилцагч цэцэрлэг, сургуулиуд нь хүнсний бараа бүтээгдэхүүний хүүхдийн тоонд харгалзан үзэж долоо хоногоор тооцож захиалах

4.8 Хүнсний бараа бүтээгдэхүүнийг хадгалалтын горимыг зөрчихгүйгээр зөв хадгалах, бэлэн болон түүхий эд бараа бүтээгдэхүүнийг тусад хадгалах

4.9 Хүнсний бараа бүтээгдэхүүний хадгалалын горим заавар зөвлөгөөг манай байгууллага нь зөвлөн туслах үйлчилгээнд арга зүйн зөвлөмж өгч ажилладаг.

4.10 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг цэцэрлэгээс татан авах дотоод журам, зааврыг баталж, татан авах үйл ажиллагааг хариуцсан ажилтан, албан тушаалтныг (цаашид “татан авалт хариуцсан ажилтан” гэх) томилон ажиллуулна;

4.11 Цэцэрлэгээс шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг 24 цагийн дотор багтаан татан авах үйл ажиллагааг зохион байгуулж, энэхүү журмын хавсралтад заасан “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах үйл ажиллагааг бүртгэх, мэдээлэх маяг” бүртгэлийг хөтлүүлнэ;

4.12.Татан авалт хариуцсан ажилтнаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг цэцэрлэгт түгээсэн талаархи бүртгэлийн дагуу тухайн түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэгдсэн, борлуулагдсан болон үлдэгдэл тоо хэмжээний судалгаа гаргуулж, татан авах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тоо, хэмжээг тооцно;

4.13.Татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж, татан авсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэн, хаяг, тэмдэг тавьж, бусад бүтээгдэхүүнээс тусгаарлан битүүмжилж захирлын шийдвэр гартал хадгална;

4.14.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авч дууссан тухай дүнгээ дээд албай тушаалтандaa мэдээлнэ;

4.15.Мэдээлэлд тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авч байгаа шалтгаан, гаган авалтын явцад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, сэрэмжлүүлэг, цаашид авах бусад арга хэмжээг тусгасан байна;

4.16 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаархи мэдээлэл, баримт бичгийг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.4, Архивын тухай хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгжийн архивын журамд заасны дагуу хадгална.

4.17.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий ад бүтээгдэхүүнийг буцаан болон татан авсан, тэдгээртэй холбогдсон арга хэмжээний талаарх мэдээлэл, баримт бичгийг хадгална.

Тав. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг актлах, устгах

5.1.Хүний амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон эсхүл гарал үүсэл нь , тодорхойгүй, түргэн муудаж чанар байдлаа алддаг, зориулалтыг нь өөрчлөн ашиглах боломжгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг актлах, устгах эсэхийг захиралын зөвлөл шийдвэр гаргана.

Зургаа. Түүхий эд бүтээгдэхүүнийг харилцагч байгууллагад буцаан олгох

6.1.Дээд албан тушаалтны шалгалтын явцад бүтээгдэхүүн эрүүл ахуйн болон аюулгүйн үзүүлэлтийг хангаагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг тогтоосон тохиолдолд холбогдох албан тушаалтан харилцагч компанийн хүнсний мэргэжилтэнтэй холбогдон утасаар болон албан бичгээр тус тус мэдэгдэж буцаах эсвэл актлах арга хэмжээ авна;

6.2.Ийм алдаа дутагдал гаргавал гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Долоо. Хариуцлага

7.1. Цэцэрлэгээс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, дахин боловсруулах, устгах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал болон лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Найм. Бусад

8.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шаардлага хангаагүй талаархи мэдээллийн эсрэг холбогдох этгээдэд гомдол гаргах эрхтэй.

8.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах талаархи шийдвэрийг эс зөвшөөрч байгаа бол гомдлоо төрийн захиргааны зохих шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж болно.

“ӨСВӨР-ҮЕ ХҮС” ОНӨААТҮГ

“.....” ЦЭЦЭРЛЭГТ

20.... оны...сарын...өдөр

Тайлбар хүргүүлэх тухай

Бараа бүтээгдэхүүний онцлог:

Тайлбар:.....

“ΕСВӨР-ҮЕ ХҮС” ОНДААТЫГ

"....." XXX

20.... оны...сарын...өдер

Тайлбар хүргүүлэх тухай

Бараа бүтээгдэхүүний онцлог:

Тайлбар:.....

Тайлбар бичсэн:

Албан тушаал: /

Тэмдэг Гарын үсэг:...../

Хүлээн авсан нярав:...../

Утас:

Тайлбар бичсэн:

Албан тушаал: / /

Тэмдэг Гарын үсэг:..... / /

Хүлээн авсан нярав:..... / /

Утас

"ӨСВӨР ҮЕ ХҮНС" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРДЫН
... оны ... дугаар сарын ... -НЫ
ЕДРИЙН ... дугаар тушаалын хавсралт



БУЦААЛТ

Аж ахуй нэгж байгууллага:		"ӨСВӨР ҮЕ ХҮНС" ОНӨААТҮГ	
Хаяг:		Хаяг:	
Албан тушаал:		Албан тушаал:	
Овог нэр:		Овог нэр:	
Утас:		Утас:	
Гомдол гаргасан өдөр			
Бүтээгдэхүүний нэр :			
Үйлдвэрлэсэн он сар өдөр, дуусах хугацаа:			
Бүтээгдэхүүний зураг	Гомдол шийдвэрлэх арга		
	Шийдвэрлэсэн байдал		
	Дүгнэлт		

БУЦААЛТ ҮЙЛДСЭН:

ЭРҮҮЛ АХУЙЧ
ЭРҮҮЛ АХУЙЧ
ХҮЛЭЭН АВСАН

Г.ЭНХБУД
Б.БОЛОРТУЯА